

**ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАГДСАН ИНД-39-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ**

<p align="center"><b>НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАРЫН УДИРДАМЖ</b> (Шинэчлэгдэж байгаа) /6 хуудас/ 2007 оны NZ amend.1</p>	<p align="center"><b>Нислэгт тэнцэх чадварын удирдамж</b> (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) /5 хуудас (үндсэн дүрэм-14 хуудастай байсан)/ 1997 оны NZ original</p>	<p align="center"><b>Тайлбар</b></p>
<p><b>А Бүлэг — Ерөнхий зүйл</b></p>	<p><b>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b></p>	
<p><b>39.1. Зорилго</b> Энэ Дүрэм нь дараах шаардлагыг тогтооно:</p> <p>(1) <u>үйл ажиллагаа эрхлэгчийн</u> НТЧ-ын Удирдамжийн хэрэгжүүлэлт;</p> <p>(2) НТЧ-ын Удирдамжид заасан шаардлагыг хэрэгжүүлэлтийн өөр хэлбэрээр хангах зөвшөөрөл.</p>	<p><b>39.1. Зорилго</b> (а) Энэ дүрмийн зорилго нь дараах үйл ажиллагаанд холбогдох журмыг тогтооход оршино:</p> <p>1/ <u>агаарын тээвэрлэгч</u> Нислэгт тэнцэх чадвар (цаашид НТЧ гэх)-ын удирдамжийг гүйцэтгэх;</p> <p>2/ НТЧ-ын удирдамжид заагдсан шаардлагуудыг өөр арга хэрэгслээр гүйцэтгэх ажиллагааг баталгаажуулах.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>- “агаарын тээвэрлэгч”гэснийг “үйл ажиллагаа эрхлэгч” гэж өөрчлөгдсөн</p>
<p><b>39.3. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх</b> Дарга энэ дүрмийн <u>39.51</u>-ийн шаардлагаас чөлөөлөхгүй.</p>	<p><b>39.3. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх</b> (а) Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ гэх)-ын дарга нь энэ дүрмийн <u>39.52</u>-д заасан шаардлагаас аливаа этгээдийг чөлөөлөхгүй.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><b>В Бүлэг НТЧ-ын удирдамж</b></p>	<p><b>Б БҮЛЭГ. НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАРЫН УДИРДАМЖ</b></p>	
<p><b>39.51. Хэрэгжүүлэлт</b> (а) <u>Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийг</u> дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөхгүй:</p> <p>(1) Хуульд заасны дагуу <u>Даргын</u> гаргасан, хамааралтай НТЧ-ын Удирдамж бүрийг хангасан байх;</p> <p>(2) агаарын хөлгийн хувьд:</p> <p>(i) тухайн агаарын хөлгийг зохион бүтээгч улсын гаргасан хамааралтай НТЧ-ын удирдамж бүрийг хангасан байх;</p> <p>(ii) тухайн агаарын хөлөгт ашиглагдаж байгаа нисэхийн бүтээгдэхүүнийг зохион бүтээгч улсын гаргасан хамааралтай НТЧ-ын удирдамж бүрийг хангасан байх; эсхүл</p> <p>(3)энэ хэсгийн (1) болон (2)-т заасны дагуу, тухайн агаарын хөлөгт хамааралтай НТЧ-ын Удирдамжийг 39.53-ын дагуу <u>Даргын</u> зөвшөөрсөн хэрэгжүүлэлтийн өөр хэлбэрээр хангасан байх.</p> <p>(b) Хэрэв <u>Даргаас</u>, агаарын хөлгийн Яаралтай НТЧ-ын Удирдамжийн мэдэгдэл авсан этгээд нь тухайн агаарын</p>	<p><b>39.52. Нислэгт тэнцэх чадварын удирдамжийг гүйцэтгэх</b> (а) <u>Агаарын тээвэрлэгч</u> нь ИНД-39.55 (а)-д зааснаас бусад тохиолдолд дараах шаардлагыг хангаагүй тохиолдолд агаарын хөлгөөр аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>1/ <u>ИНЕГ</u>-ын даргын гаргасан, тухайн агаарын хөлөгт хамаарах НТЧ-ын удирдамж бүрийг гүйцэтгэсэн байх;</p> <p>2/ Монгол Улсад бүртгэлтэй бүх агаарын хөлөгт дараах НТЧ-ын удирдамжийг гүйцэтгэсэн байна:</p> <p>2.1 агаарын хөлгийн зохион бүтээгч улсаас гаргасан тухайн агаарын хөлөгт хамаарах НТЧ-ын удирдамж бүрийг; болон</p> <p>2.2 агаарын хөлөгт ашиглагдаж буй нисэхийн бүтээгдэхүүний зохион бүтээгч улсаас гаргасан хамаарал бүхий НТЧ-ын удирдамж; эсхүл</p> <p>3/ энэ зүйлийн 1/ болон 2/-т заасан агаарын хөлөгт хамаарах НТЧ-ын удирдамжийг 39.53-ын дагуу <u>ИНЕГ</u>-ын даргын баталсан өөр арга хэрэгслээр гүйцэтгэсэн байх.</p> <p>(б) <u>ИНЕГ</u>-ын даргаас агаарын хөлөгт яаралтай гүйцэтгэх НТЧ-ын удирдамжийг мэдэгдсэн тохиолдолд тухайн агаарын хөлөг нь</p>	<p>-Орчуулга, найруулга болон дугаарлалт зассан</p> <p>-Гүйцэтгэлийн тайланг НТЧ удирдамж дээр заасан байдаг</p>

<p>хөлөгт Монгол Улсын <a href="#">бүртгэлийн гэрчилгээ эзэмшдэггүй</a> бол, гэрчилгээ эзэмшигч биш болохоо <a href="#">Даргад</a> нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.</p>	<p>Монгол улсын <a href="#">бүртгэлгүй</a> бол энэ тухай агаарын хөлгийн гэрчилгээ эзэмшигч нь <a href="#">ИНЕГ</a>-ын даргад яаралтай мэдэгдэнэ.</p> <p>(в) НТЧ-ын удирдамжийн гүйцэтгэлийн мэдээг удирдамжийг гүйцэтгэж дууссанаас хойш 7 хоногийн дотор, яаралтай удирдамжийн гүйцэтгэлийн тайлан мэдээг гүйцэтгэж дууссанаас хойш 3 хоногийн дотор <a href="#">ИНЕГ</a>-ын даргад ирүүлнэ.</p> <p>(г) НТЧ-ын удирдамжийг гүйцэтгэхээр төлөвлөсөн тухай мэдээг тухайн НТЧ-ын удирдамжийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор <a href="#">ИНЕГ</a>-ын даргад ирүүлнэ.</p>	
<p><b>39.53. Хэрэгжүүлэлтийн өөр хэлбэр</b></p> <p>(а) Энэ дүрмийн <a href="#">39.51</a>(а)(1) болон (а)(2)-т шаардсаны дагуу НТЧ-ын Удирдамжийн шаардлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй <a href="#">агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч</a> нь тухайн НТЧ-ын Удирдамжид заасан шаардлагыг хэрэгжүүлэлтийн өөр хэлбэрээр хангах зөвшөөрөл авах хүсэлтийг <a href="#">Даргад</a> гаргаж болно.</p> <p>(б) Энэ зүйлийн (а)-ийн дагуу НТЧ-ын Удирдамжийг хэрэгжүүлэлтийн өөр хэлбэрээр хангах зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь:</p> <p>(1) САА 24039/01 маягыг бөглөж;</p> <p>(2) зохих төлбөрийн баримтын хамт <a href="#">Даргад</a> хүргүүлэх үүрэгтэй.</p> <p>Хэрэв <a href="#">Дарга</a> хэрэгжүүлэлтийн өөр хэлбэрийг хэрэглэснээр, тухайн НТЧ-ын Удирдамжийн шаардлагыг хангасантай дүйцэх аюулгүй байдлын түвшнийг хангана гэж үзвэл, <a href="#">Дарга</a> тухайн НТЧ-ын Удирдамжийн хэрэгжүүлэлтийн өөр хэлбэрийг үйл ажиллагаа эрхлэгчид зөвшөөрч болно.</p>	<p><b>39.53. НТЧ-ын удирдамжийн гүйцэтгэлийн өөр арга хэрэгсэл</b></p> <p>(а) ИНД-<a href="#">39.52</a> (а)-ийн 1/ болон 2/-т заасан <a href="#">агаарын хөлгийн эзэмшигч</a> нь НТЧ-ын удирдамжийн шаардлагуудыг биелүүлэх зорилгоор тухайн НТЧ-ын удирдамжид зааснаас өөр арга хэрэгслээр гүйцэтгэх тохиолдолд зөвшөөрөл авахаар <a href="#">ИНЕГ</a>-ын даргад хандаж болно.</p> <p>(б) Энэ зүйлийн (а)-ийн дагуу өөр арга хэрэгслээр НТЧ-ын удирдамжийг гүйцэтгэхээр зөвшөөрөл авах өргөдөл гаргагч нь:</p> <p>1/ <a href="#">ИНЕГ</a>-39/01 маягыг бөглөх; ба</p> <p>2/ үйлчилгээний төлбөрийн баримтын хамт <a href="#">ИНЕГ</a>-ын даргад ирүүлнэ.</p> <p>(в) НТЧ-ын удирдамжид заасан шаардлагуудад тэнцэхүйц, ижил хэмжээний аюулгүй ажиллагааны түвшинг хангасан гэж үзсэн тохиолдолд НТЧ-ын удирдамжийн гүйцэтгэлийн өөр арга хэрэгслийг <a href="#">ИНЕГ</a>-ын дарга зөвшөөрч болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-“агаарын хөлгийн эзэмшигч”гэснийг “агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч” гэж өөрчлөгдсөн</p> <p>-“ИНЕГ-ын дарга” гэснийг “Дарга” гэж өөрчлөгдсөн</p>
<p><b>39.55. Хойшлуулсан хэрэгжүүлэлт</b></p> <p>Хэрэв НТЧ-ын Удирдамж нь агаарын хөлөг, эсхүл агаарын хөлөгт суурилуулсан нисэхийн бүтээгдэхүүнд дараалсан цуврал үзлэг шалгалт хийхийг шаардсан бол <a href="#">агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч</a> нь НТЧ-ын удирдамжаар тусгайлан хориглосноос бусад тохиолдолд, анхан шатны үзлэгээс бусад шаардлагатай үзлэг шалгалтыг НТЧ-ын Удирдамжид заасан үзлэг шалгалтын давтамжаас 10 %-иас <a href="#">ихгүй хугацаагаар</a> хойшлуулж, бусад хуваарьт техник үйлчилгээний үед гүйцэтгэхийг зөвшөөрч болно.</p>	<p><b>39.55. НТЧ-ын удирдамжийн гүйцэтгэлийг хойшлуулах</b></p> <p>(а) Хэрэв НТЧ-ын удирдамжид шаардсаны дагуу дараалсан үзлэгийг агаарын хөлөг эсхүл түүнд суурилуулсан нисэхийн бүтээгдэхүүнд хийх тохиолдолд <a href="#">Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийн гэрчилгээ эзэмшигч</a> нь НТЧ-ын удирдамжид тусгайлан хориглоогүй бол, анх удаа хийгдэх үзлэгээс бусад тохиолдолд тухайн НТЧ-ын удирдамжид заасан хугацааг хуваарьт техник үйлчилгээнээс бусад үзлэгийн үед үечлэлийг 10 хувиар хойшлуулж болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p>

**39.57. НТЧ-ын хадгалалтын бусад зааварчилгаатай зөрчилдөх**

Хэрэв НТЧ-ын Удирдамжид заасан шаардлага нь НТЧ-ын хадгалалтын холбогдох бусад зааварчилгаатай зөрчилдөж байгаа бол НТЧ-ын Удирдамжид заасан тухайн шаардлага нь давамгайлна.

**39.57. НТЧ-ын удирдамж нь бусад НТЧ-ын хадгалалтын зааварчилгаатай зөрчилдөх**

(a) Хэрэв НТЧ-ын удирдамжид заасан шаардлагууд нь агаарын хөлгийн бусад НТЧ-ын хадгалалтын зааварчилгаатай зөрчилдөх тохиолдолд тухайн НТЧ-ын удирдамжид заасан шаардлагууд нь давуу эрхтэй.

-Орчуулга, найруулга  
зассан

Дүрмийн боловсруулалтын хэлтэс